



Бодол, эргэцүүлэл, санал

ХИЛ СУДЛАЛ ЮУГ СУДЛАХ ВЭ?

Тусгаар тогтносон улсын хил, хязгаар нутагт болж байгаа үйл явцын мөн чанар, шинж байдал, хилийн орон зайд хамаарагдах бие хүн, нийгэм, төрийн ашиг сонирхлыг хамгаалах төрийн болоод түүний хүчний байгууллагуудын үйл ажиллагааг судалдаг шинжлэх ухааны шинэ салбар бол "хил судлал" (погранология) юм.

Монгол улсын төрийн тусгаар тогтнолын гол шинж болсон улсын хил түүний харилцааг хилийн талаар явуулах, түүнийг бодлого болгон зохион байгуулах түүний хөгжлийн зүй тогтол объектив болоод субъектив нөхцөл байдлын харилцааны диалектик холбоонд хилийн асуудлыг авч үзэн улсын хилийн хамгаалалт бол шинжлэх ухааны шалгуур мөнийн хувьд тодорхой зорилго, зорилт, бодлого чиглэлтэй судалгаа явуулах үүднээс улсын хил судлалыг бие даасан шинжлэх ухааны зэрэгт тавьж хөгжүүлэх явдал дээвэр туурга тусдаа, дэлхийчлэлд багтсан Монгол улсын чухал зорилтын нэг болоод байна. Монгол улсын өнөөгийн хил болоод хязгаар нутгийн орон зайд өрнөж буй үйл явдалд гүнзгий дүн шинжилгээ хийж материаллаг ертөнцийн салшгүй хэсэг байгаль, нийгэм, оюун санааны бодит үзэгдэл болох хилийн асуудлыг судлахгүйгээр, хилийн асуудлыг нийгмийн дэлхийчилсэн хөгжлийн харилцаанд оруулан шинжилгээ хийхгүйгээр Монгол улсын төрөөс хилийн талаар явуулах бодлогыг оновчтой хэрэгжүүлж чадахгүй. Ийм учраас улсын хилийг судалдаг шинжлэх ухааны мэдлэгийн бие даасан салбар бий болгож, түүн дээр эрдэмтэд, судлаачдыг ажиллуулж суурь болоод хавсарга судалгаа хийлгэж улсын хил, хязгаар нутгийн улс төр, эдийн засаг, үзэл суртал, эрх зүй, олон улсын харилцааны болон экологийн зэрэг бусад асуудлыг судалж, шинжлэх ухааны онолын дүгнэлт нээлт, санал зөвлөмжүүдийг хилийн талаар явуулах төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд өргөн ашиглах учиртай болоод байна.

НҮБ-ын эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн Ерөнхий зөвлөлдөх зөвлөлийн дэргэд Олон улсын мэдээлэл зүйн академи (ОУМЗА) "Международная академия информатизации (МАИ)" үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хил судлал хэмээх шинжлэх ухааны шинэ салбарыг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор улсын

хилийн хамгаалалтад хэрэглэгдэж буй мэдээлэл зүй, мэдээллийн технологийн салбарт ажиллаж буй эрдэмтэд, мэргэжилтнүүд, төр нийгмийн зүтгэлтнүүдийг нэгтгэсэн олон улсын томоохон байгууллага болоод байна.

Оросын Холбооны Улсад Холбооны Хилийн Албаны академийн дэргэд хил судлалын үндэсний салбар байгуулагдан, бүс нутгийн шинжлэх ухааны олон нийтийн байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж олон улсын дээрх байгууллагатай хамтран ажиллаж байна.

Монгол орны нөхцөлд өнөөдөр ХЦС-ийн бүтцэд байгаа эрдэм шинжилгээний төвийг сургуулийн нь бүтцэд **"Хил судлалын төв"** болгон өргөтгөн зохион байгуулж, улмаар төрийн бус байгууллага болох **"Хил судлалын үндэсний нийгэмлэг"** байгуулж, манай орны нэр хүндтэй эрдэмтэн судлаачид, генерал офицерууд ахмад хилчид, хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэх сэтгэл зориг бүхий төр олон нийт, аж ахуйн байгууллагуудын ажилтнуудыг тус нийгэмлэгт нэгтгэж, тэдний судалгаа шинжилгээний бүтээлийг хэвлэн нийтлэх, бүтээж туурвих үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлж, 1989 онд байгуулагдсанаасаа хойш Англи улсын Дурхамын их сургууль дээр байрлаж олон улсын хилтэй холбогдсон асуудлаар дэлхий нийтийн мэдээллийн эх булгийг түгээж буй олон улсын хил судлалын байгууллагатай холбоо тогтоож тэдгээрээс зохион явуулдаг олон улсын болон бүс нутгийн арга хэмжээнд оролцож байх нь зүйтэй болохыг манай улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол шаардаж байна.

Байгаль нийгмийн харилцааны оршин байх бүх эхлэлийн их гараа болсон мэдээллийг нэгдсэн нийтлэг үндэс болгосон цорын ганц хамт олон болох энэ нийгэмлэгт Монгол улсын төр нийгмийн зүтгэлтнүүд, Монгол Улсын төрийн яамд, Хилийн Цэрэг, Улсын Гаалийн Ерөнхий Газар зэрэг агентлагууд, их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудад ажиллаж буй эрдэмтэн судлаач мэргэжилтнүүдийг тэдний сайн дурын үндсэн дээр нэгтгэх хэрэгтэй юм.

Бие хүн нийгэм болоод улсын харилцаанд нэвтрэлцэх, харилцан хязгаарлагдах шинэ сонирхлын хүрээнд хил, хязгаар нутгийн **орон зайд** улс орнуудын төрийн бодлогын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх замаар дэлхий нийтийн мэдээллийн нэгдсэн **орон зайг** төлөвшүүлэхэд туслалцаа үзүүлэхэд хил судлалын үйл ажиллагааны агуулга чиглэгдэж байна.

Бүх улс орон, ард түмэнд нээлттэй дэлхийн нэгдмэл нэг

мэдээллийн **орон зайг** буй болгох үзэл санааг хэрэгжүүлэх, мэдээллийн шинэ нийгмийг байгуулах явдал нь дэлхий дахинд тогтвортой байдлыг сахих, орон нутгийн шинжтэй зэвсэгт мөргөлдөөний эсрэг нийтээр сөрөн зогсох, дэлхий дээр болон Монгол Улс түүний хөршүүдийн дэвсгэр нутагт түгшүүртэй байдлын голомтыг устгаснаар хангагдах болно. Энэхүү механизмын үр ашгийг дээшлүүлэх хөшүүргүүдийн нэг чухал хэсэг нь хилийн талаар явуулах төрийн бодлого мөн.

Хил судлал, нийгмийн мэдээлэл зүй хоорондын диалектик холбоонд үндэслэн хил судлал нь дараахь зорилтыг тавьдаг. Үүнд:

- хилийн хамгаалалт, хязгаар нутгийн асуудлаар хамтран ажилладаг Монгол Улсын болон бусад орны хилийн цэрэгт мэдээллийн нэгдсэн орчин бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх
- хил судлалын салбарын эрдэмтэд мэргэжилтнүүдийн олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын болон бүс нутгийн их бага хурлуудад оролцох
- төр засаг, шинжлэх ухааны болон улс нийгмийн байгууллагуудаас хилийн талаар баримталж буй бодлого, үзэл бодлогыг ойртуулах зорилгоор мэдээллийн технологийг харилцан солилцох
- хилийн албаар мэргэшсэн дээд боловсролтой боловсон хүчин, мэргэжилтнүүдийг бэлтгэхэд туслалцаа үзүүлэх,
- дэлхий нийтийн мэдээлэл, мэдээлэл зүйг шинэ технологийн зарчмын үндсэн дээр улсын хилийн талаар явуулах төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх зүй тогтолт үзэл бодлыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх,
- хэвлэн нийтлэх үйл ажиллагааг санаачилж идэвхитэй оролцох,
- улсын хил, хязгаар нутгийн болон улс хоорондын хилийн асуудлаар үзэсгэлэн гаргах семинар сургалт, симпозиум, уралдаан бусад арга хэмжээг зохион байгуулах,

Эдгээр зорилтод хүрэх гол чиглэл нь хил судлалын эрдэм шинжилгээ судалгааны үйл ажиллагаагаар тодорхойлогдох ёстой. Энэ асуудалд хамаарах бусад чиглэлүүдэд эрдэм шинжилгээ зохион байгуулалтын, сургалт мэдээллийн болон хэвлэн нийтлэх ажлыг багтааж байна.

Эрдэм шинжилгээ судалгааны үйл ажиллагаа нь харилцан уялдаа бүхий дараахь нэгдмэл ажлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн

суурь болоод хавсарга судалгааг хамруулдаг. Энэ нь:

-улсын хил, хязгаар нутаг, түүний орон зайд бие хүн, нийгэм, төрийн ашиг сонирхлыг хамгаалах салбарт явуулах мэдээлэл зүй-дүн шинжилгээний үйл ажиллагаа, улсын хил хязгаар нутагт өрнөж буй цагийн байдлын хэвийн нөхцөлийг хангахад орчин үеийн мэдээллийн технологийг нэвтрүүлэх, түүний хөгжлийг урьдчилан оношилж загварчлах,

-хүчний байгууллагуудын дээд сургууль болон боловсролын бусад байгууллагын сургалт, эрдэм шинжилгээний явцын мэдээлэл зүй

-улсын хил, хязгаар нутгийг хамгаалах ашиг сонирхолд ашиглагдаж буй иргэний эрүүгийн, төрийн болон олон улсын хууль, монгол улсын болон хөрш зэргэлдээх орнуудын хил хязгаар нутаг, хил орчмын орон зайн нийгэм улс төр, нийгмийн болон эдийн засгийн асуудлууд,

-Монгол Улсын хилийн цэрэг, улсын хил хязгаар нутаг, түүний орон зайг хамгаалж буй үйл ажиллагааны онол арга зүй, технологи, түүний янз бүрийн хүрээнд хийх математикийн загварчлал,

-мэдээлэл зүйн үйл ажиллагааны сэтгэл зүйн хангалт зэрэг болно.

Энд тоймлон өгүүлэхэд хил судлал гэсэн жинхэнэ агуулгаараа зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулаагүй ч гэсэн ХЦС-ийн эрдэм шинжилгээний төвөөс эрдэмтэд судлаачдынхаа хүчээр нэлээд товхимол, нэг сэдэвт зохиол, зарим төсөл боловсруулж хэвлүүлсэн нь монгол оронд хил судлалын шинжлэх ухааны салбарыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх хөрс суурь байсныг нотлон харуулж байна.

Тухайлбал сүүлийн жилүүдэд дэд доктор, дэд профессор Ш.Арвай "Эгэл хилчдийн ээдрээт замын сургамж", "Монгол улсын хил хамгаалах салбарын албаны бэлэн байдал", доктор, дэд профессор С.Жанцан "Монгол улсын эрүүгийн эрх зүй, кримнологийн үндэс", магистр, дэд профессор Б.Лхагва "Аж ахуйн гэрээ", "Цэргийн аж ахуйн сурах бичиг", "Хилийн цэргийн хангалт үйлчилгээнд түгээмэл хэрэглэгдэх нэр томъёоны тайлбар толь", магистр Ч. Дашдэлэг "Улсын хил хамгаалалтын өнгөлөн далдлалт", магистр, дэд профессор П. Даш "Хилийн харуул", магистр Д. Батсүх "Хилийн эрэл" зэрэг ном товхимол гарын авлагуудыг хэвлэн гаргасны дээр "Хилийн цэргийн бие бүрэлдэхүүний сургалтын тогтолцоо, хөтөлбөрийг боловсронгуй болгох нь", "Монгол улсын өмнөд хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох арга зам" (Ч.Дашдэлэг) "Хилийн боомтын журмыг боловсронгуй

болгох арга зам" (Г.Төртогтох), "Монгол Улсын төрийн хилийн бодлого хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий хөтөлбөр" (Ш.Арвай) зэрэг судалгааны ажлуудыг захиалгаар гүйцэтгэж захиалагч байгууллагад "онц", "сайн" үнэлэлгээтэйгээр хүлээлгэн өгсөн юм.

Эрдэм шинжилгээ зохион байгуулалтын үйл ажиллагаа нь эрдэм шинжилгээ судалгааны асуудлуудад дүн шинжилгээ хийх, тэдгээрийг иж бүрнээр авч үзэн шийдвэрлэх ажлын төлөвлөгөөг боловсруулах, цаашид "Хил судлалын үндэсний нийгэмлэг"-ийн гишүүд болон төрийн яамд агентлагууд их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудын мэргэжилтнүүдийг татаж оролцуулах замаар хил судлаачдын бүтээлч хамт олныг бүрдүүлэх, шинжилгээ судалгааны ажил, төслүүдийн үр дүн тэдгээрийг түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад чиглэгдэх учиртай.

Нийгэмлэгийн гишүүд нь БХЯ-ны болон ХЦУГ-ын шинжлэх ухаан техникийн зөвлөлийн ажилд оролцож БХИС-ийн салбар сургуулиуд, удирдлагын академи, Цагдаагийн дээд сургууль, МУИС-ийн ОУХДС зэрэг эрдэм шинжилгээний байгууллагуудтай нягт хамтран ажиллах ёстой.

Хил судлалын төв нь ХЦС-ийн бүтцэд багтаж түүний салшгүй хэсэг байдгийн хувьд тус сургуулийн сургалт эрдэм шинжилгээний үйл ажиллагааг нягт уялдуулж их сургуулийн хэмжээнд хилийн цэргийн боловсон хүчнийг бэлтгэх, офицер ажилтнуудыг давтан сургахад хамгийн идэвхитэй оролцох ёстой. Сургалтын үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, лекц унших, семинар явуулах, "Дугуй ширээний ярилцлага" мэтгэлцээн зохиох, зөвлөлгөөн, бага хурал хийлгэх, магистрант, докторант, горилогчдын ажлыг удирдах, фондын болон цуврал лекц боловсруулах, хил судлалын асуудлаар сурах бичиг гарын авлага бичиж туурвихад оролцож тэдгээрийг зохион байгуулах үүрэгтэй. Үүнээс гадна нийслэл болон бусад аймаг хотуудад хил судлалын асуудлаар зохиогддог олон улсын бага хурал, симпозиум, эрдэм шинжилгээний байгууллага хүрээлэнгүүдээс зохион байгуулдаг бусад арга хэмжээнд багш, сонсогчид, магистрант, докторантуудыг өргөнөөр оролцуулах бөгөөд тэд зөвхөн эрдэм шинжилгээний ажлын зорилгоор бага хурал, семинарын индэр ашиглахаар хязгаарлагдахгүй бас хил судлалын шинжлэх ухааны ертөнцийг үзэх үзлийн мөн чанар болох үндэсний эх оронч философийн үзэл санааг сурталчлах ёстой.

Эрдэм шинжилгээний ажлын бүтээлч сэтгэлгээ, авьяас, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор ХЦС-ийн сонсогчид, багш нарын дунд жил бүр эрдэм шинжилгээ судалгааны шилдэг бүтээлийн уралдаан

зарлаж шалгарсан хүмүүсийг диплом, мөнгөн шагналаар шагнаж бүтээлийг нь хэвлэл мэдээллээр сурталчилж байх нь зүйтэй байна.

Мэдээллийн үйл ажиллагаа нь олон улсын хил судлалын болон мэдээлэл зүйн академи, хөрш гүрнүүд бусад улсын ижил төстэй байгууллагууд, өөрийн нийгэмлэгийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг сурталчлах, олон улс бүс нутгийн байгууллага хоорондын болон бүс нутгийн симпозиум, бага хурал, сургалт, семинарт оролцох тэдгээр байгууллагуудтай байнгын мэдээлэл солилцох, Монгол Улсын хилийн цэрэгт мэдээллийн соёлыг дээшлүүлэх чиглэгдэнэ.

Мэдээлэл зүйн зорилгыг хэрэгжүүлэхэд хэвлэн нийтлэх үйл ажиллагаа чухал ач холбогдолтой. Хил судлалын төвөөс болон нийгэмлэгээс өөрийн хэвлэл "Хил судлал" сэтгүүлийг 2 сар тутам гаргаж орон даяар түгээн сурталчлах ажлыг тогтмолжуулахаас гадна ХЦС дээр эрдэмтэд судлаачдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж, Монгол Улсын хилийн отряд, застав хязгаар нутгаар эрдэмтэд лекторын тойрон аяллыг олон хэлбэрээр явуулж байх хэрэгтэй.

Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын гол шинж болсон улсынхаа хилийг бат найдвартай байлгахад үйлчлэх хил судлалыг үүсгэн хөгжүүлэх эрмэлзэлтэй эх орончид энэ үйл ажиллагааг дэмжинэ гэдэгт итгэж байна.

Доктор (Ph D), дэд профессор Г.Дагважамц